



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар Д/380

Хэрлэн сум

Инженерийн хийцтэй худаг хүлээн
авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь заалт, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 101/189/194 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн завсарлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Улсын төсөв, төсөл хөтөлбөр болон орон нутгийн төсөв хөрөнгөөр хөдөөгийн хүн ам мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 18 сумын нутагт шинээр гаргаж буй инженерийн хийцтэй худгийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын

дарга:

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Нарийн бичиг:

Гүйцэтгэгч компанийн төлөөлөл

Гишүүд:

Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтийн хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Бэлчээр, тэжээл, усан хангамж хариуцсан мэргэжилтэн


Аймгийн төслийн ажилтан

Сумдын Засаг дарга

Сумдын ХАА тасгийн мэргэжилтэн

Хоёр.Шинээр гаргасан инженерийн хийцтэй худгийг MMS 6088:2010 стандарт, техникийн тодорхойлолт, зөвлөмжид заасан баримт материалын дагуу хүлээн авч, дүгнэлтээ танилцуулахыг комиссийн дарга (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ЧОГСОНЖАВ